

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ

ПЕГИКОЛОР ХХК
БАТЛАВ
ПЕГИ КОЛОР ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц.МӨНГӨН-ЭРДЭНЭ

КОВШ МАШИНЫ ХРОП ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 111/2022

20²² оны 10-р сарын 12 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Пегикоколор ХХК-ийг төлөөлж захирал Ц.Мөнгөн-Эрдэнэ /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Ковш машины хроп” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлж, угсарч, суурилуулж өгнө.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 5 /тав/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 10,300,000 /арван сая гурван зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 10 /арав/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5014414658 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн АХММХМ инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана. Утас- 98109919.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Пеги колор ХХК-ийн захирал Ц.Мөнгөн-Эрдэнэ хариуцан ажиллана. Утас- 99045264.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон чанар стандартад нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 3 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг баталгаат хугацаанд өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1. Нийлүүлэгчийн ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид угсарч, суурилуулж хүлээлгэн өгөх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 3 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.


Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 10 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлана.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл


- 9.1.Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 3 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2.Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3.Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

АХММХМ ИНЖЕНЕР
Н.САЙНБИЛЭГ
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНТУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Хаяг: УБ хот СХД 19-р хороо 21-р хороо
Цахилгаан тээвэр хашаа 1-тоот
Утас: 99045264
РД: 5497205

.....Тоот гэрээний хавсралт

**Ковш автомашины хропны
сэлбэг хэрэгсэл нийлүүлэх барааны жагсаалт**

2022.10.04

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Гүзээ диск	ком	1	1,950,000	1,950,000
2	Явахын насос	ш	1	380,000	380,000
3	2-р араа ком	ком	1	1,450,000	1,450,000
4	Ком жийрэг	ком	1	210,000	210,000
5	Ком сальник	ком	1	320,000	320,000
6	Ком шариг	ш	10	65,000	650,000
7	Галижа	ш	1	620,000	620,000
8	Зэс диск	ш	12	60,000	720,000
9	Ган диск	ш	12	60,000	720,000
10	Түгжээ араа	ш	1	1,950,000	1,950,000
11	Хропны шүүр	ш	2	145,000	290,000
12	Хувиарлагч	ш	1	420,000	420,000
13	3-р гол араа	ш	1	340,000	340,000
14	2-р гол араа	ш	1	280,000	280,000
	НӨАТ-ай НИЙД ДҮН				10,300,000

Бүх сэлбэг хэрэгслийг сольж, угсарч өгнө.

Баталгаат хугацаа 3 сар.



ПЕГИ КОЛОР ХХК-ийн захирал  Ц.МӨНГӨН-ЭРДЭНЭ

"Амгалан Дулааны Станц" ТӨХК-ийн

АХММХ-ийн механик инженер 

Н.САЙНБИЛЭГ